

ХОРИГДЛЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТЭД ХИЙСЭН СУДАЛГАА

A RESEARCH ON THE LABOR OF PRISONERS

**Г.Гансүх***Дотоод хэргийн их сургуулийн**Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
магистрант, ахмад*

Товч утга: Хоригдлыг нийгэмшүүлэх ажлын суурь нь хоригдлын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн дадал олгохтой холбоотой сургалтууд гэж үзэж болно. Хоригдлоор хөдөлмөр эрхлүүлэх нь нийгэмшүүлэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, Хоригдлын хөдөлмөрийг зөв зохион байгуулах, хууль тогтоомжийн зарим зүйл заалтад нэмэлт өөрчлөлт оруулах замаар үр нөлөөг нэмэгдүүлэх боломжтой.

Түлхүүр үгс: Хоригдлын хөдөлмөр эрхлэлт үйлдвэрлэл, хөдөлмөрийн үр нөлөөг дээшлүүлэх, дахин гэмт хэргийг гарах эрсдлийг бууруулах, нийгмийн ажлын үр нөлөөг дээшлүүлэх.

Key words: employment of prisoners, improvement of labor efficiency, reduction of the risk of recidivism, improvement of the effectiveness of social work.

2015 онд болсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблейн 70 дугаар чуулганаар томоохон шийдэл бол Тогтвортой хөгжил-2030" буюу Тогтвортой хөгжлийн 17 зорилго байв. Уг зорилго нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн үндсэн 3 суурь асуудалд төвлөрдөг ба шударга, амар амгалан, бэхэжсэн байгуулал бүхий нийгмийг төлөвшүүлэх нь томоохон нэг зорилго юм. Хоригдлыг засан хүмүүжүүлэх, тэднийг ял эдлээд гарсны дараах чөлөөт амьдралд бэлтгэхэд хоригдлын хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол олгох болон чөлөөт цагийг зохистой ашиглах зэрэг ажлыг зөв зохион байгуулах нь чухал. Хоригдлын хөдөлмөр эрхлэлт бол нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхэд хамгийн чухал асуудал. Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар улс бүр ялгаатай ханддаг байна. Эрүүл нийгмийг бүтээхэд шүүхээс гарсан шийдвэрийг хуулийн хүрээнд зарчим, зорилгод нийцүүлж хэрэгжүүлэх нь чухал. Ялангуяа үйлдсэн гэмт хэрэгтэй хорих ял шийтгүүлсэн этгээдийг нийгэмшүүлж, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх чадварт суралцуулах, суллагдан гарч, бусад иргэдийн адил хөдөлмөрлөж амьдрахад бэлтгэх явдал юм.

Иймд өгүүллийн хүрээнд хоригдлыг дахин нийгэмшүүлэх ажиллагаанд хөдөлмөрийн гүйцэтгэх үүрэг, хоригдлын хөдөлмөрийг зохион байгуулахад

анхаарах асуудлуудыг нээн илрүүлж, шийдвэрлэх арга замын талаарх өөрийн дүгнэлт, саналыг гаргахыг зорилоо.

Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршдог.

Үүнээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх зорилгыг хангахад тухайн хорих ялаар шийтгүүлсэн хоригдлоор хөдөлмөр эрхлүүлэх явдал чухал үүрэг гүйцэтгэж байна. Пенитенциар сэтгэл судлалд хоригдлоор хөдөлмөр эрхлүүлэхийн үндсэн 4 ач холбогдлыг тодорхойлсон байдаг. Үүнд:

Нийгэм-эдийн засгийн хөгжил иргэн бүрийн хөдөлмөрлөх чадамж, ажлын байр, хөдөлмөрийн бүтээмжээс шалтгаалж байдгийн хувьд хоригдол нь бүтээн байгуулалт, аж ахуйн ажилд оролцсоноор нийгмийг бүрдүүлэгч гишүүн болохоо мэдэрч, нийтийн зорилгод хувийн зорилгоо чиглүүлэх, тодорхой зөв зорилготой болох хандлагыг төрүүлдэг.

1. Нийгмийг бүтэц талаас авч үзсэн ч, хүнийг мөн чанар талаас нь авч үзсэн ч хамааралтай байх нь суурь хэрэгцээнүүдийн нэг бөгөөд хөдөлмөрлөх нь аминч үзлийг дарж, харилцан тусалж, хамт олонч төлөвшилийг бий болгодог.

2. Зөв зохион байгуулалттай, тогтмол хөдөлмөр нь хүнд зөв дадал зуршил бий болгохын зэрэгцээ амьдралаа шударга хөдөлмөрөөр залгуулах, үнэ цэнийг мэдрэх, бусдын хөдөлмөрийг үнэлэх, аливаа үйл ажиллагаанд ухамсартайгаар оролцох, үйлдэх зоригийн шинжийг хөгжүүлдэг.

3. Хорих ялын онцлогт хоригдлыг олон нийтээс тусгаарлан байрлуулах үйл ажиллагаа ордог. Өдөр тутмын хэмнэлээс тухайн хоригдлуудыг албадлагаар холдуулснаас чөлөөт цаг үүсэх явц өрнөдөг нь хоригдлын бие физиологи, сэтгэцийн эрүүл мэндэд тодорхой нөлөөлөл үзүүлдэг. Тиймээс ялын тодорхой хугацааг үр дүнтэй ашиглаж, хөдөлмөр эрхлэхэд зориулах нь эрүүл чийрэг биетэй байх, сэтгэл зүйж хувьд аливаа хямралд өртөж, сөрөг, улигт бодолд автах, тулгамдсан асуудал нь даамжрахаас сэргийлэх томоохон ач холбогдолтой юм.

Монгол улсад Хоригдлын хөдөлмөрлүүлэхтэй холбоотой түүхэн сурвалжийг авч үзвэл Богд Хаант Монгол улсын үед гянданаа хоригдож ял эдлэгсдийг хөдөлмөрт хамруулан, тэднийг хөдөлмөрийн үр нөлөөгөөр хүмүүжүүлэх ажлын эхлэл тавигдаж байсныг зарим түүхэн баримт бичигт оруулсан байдаг. Монгол улсын шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэх яамны 1916 оны 12-р сарын 11-ний өдрийн бичигт: “Аливаа дөнгө дөнгөлөх ял халдагсдыг Нийслэл Хүрээний хог буртаг цэвэрлүүлэн жигшүүлэн хүмүүжүүлэхээр шийдвэрлэсэн” тухай өгүүлжээ. Энэ байдал нь тухайн төрлийн хөдөлмөр нэг талаар залхаан цээрлүүлэх, нөгөө талаар хүмүүжлийн хэрэгсэл болж байсныг харуулж байна. 1924 оны 11 дүгээр сард хуралдсан Улсын анхдугаар их хурал, мөн онд хуралдсан Монгол Ардын намын III Их хурлаас хувьсгалт Монгол Улсын Хорих ял эдлүүлэх байгууллагын практик, үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын үндсэн чиглэл, зарчмыг тодорхойлж өгсөн байна. МАН-ын III Их хурлын тогтоолд Гянданаа хоригдсон хэрэгтэн ардын үйлдвэрт сургах, сургаж гэгээрүүлэх, аливаа шүүхийн тогтоолгүйгээр хэнийг ч хорихгүй байх, гяндан хорооны байдал муу байгааг сайжруулах, насанд хүрээгүй хөвгүүд) охид хэрэгт холбогдох тохиолдолд гянданаа хорихгүйгээр...гэгээрүүлэх, аливаа хэрэгтэн

ардын дотроос хүн төлөв, засрах байдалтайг нь гянданаа хорихгүйгээр үйлдвэр хийлгэвэл зохих зэргийг онцлон заажээ.

1940 оноос Засан хүмүүжүүлэх үйлдвэрийн лагериуд ба хорих ангиудыг удирдах газар болгон өргөтгөн зохион байгуулалтыг нэмэгдүүлсэн байна. 1981 оноос Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагуудын удирдах газар, 1992 оноос Хорих ангиудыг удирдах газар гэж нэрлэх болсон байна.

1940-өөд он хүртэл засан хүмүүжүүлэх, 1940-1980 оны хооронд тухайн үеийн төвлөрсөн төлөвлөгөөт үеийн үйлдвэрлэлд хоригдлын хүч хөдөлмөрийг шингээхэд зөв бодлого хэрэгжүүлж байсан ба энэ нь агуулгын томоохон өөрчлөлт байсан юм. Тухайн үеүдэд Орос улсаас багш, ажилтнуудын тусламжтайгаар төрөл бүрийн мэргэжил эзэмшүүлж, хөдөлмөрийн дадал олгож, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, уул уурхайн үйлдвэрлэл, оёдол, гар урлал, мужаан дархан, мал аж ахуй, газар тариалан зэрэг бусад үйлдвэрлэлийг тасралтгүй явуулж байсан байна.

1960-аад оноос ял эдлэгсдийн хөдөлмөрийн үр нөлөөгөөр хүмүүжүүлэх ажлыг хүмүүжил-сургалтын бусад ажилтай зөв хослуулан эрчимжүүлэхтэй холбогдсон шинэ шаардлага тавигдсан гэж үздэг. Мөн үеэс ял эдлүүлэх байгууллагын үйлдвэрлэл эрчимтэйгээр нэмэгдэж улсаас тодорхой хэмжээний төлөвлөгөө норм тогтоож өгдөг болсон байна. Уг арга хэмжээ нь улс орны хөгжилд хоригдлуудын оролцоог нэмэгдүүлж, тэдэнд нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг ухамсарлуулахад томоохон түлхэц болсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай 2002 оны хуулийн 106 дугаар зүйлийн 106.2- т *Хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэл, ажлын байрны асуудлыг аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг харгалзан Засгийн газар шийдвэрлэнэ* гэж заасан нь хоригдлыг ажлын байраар хангах асуудалд орон нутгийн засаг даргын нэг үүрэг болсон нь чухал ач холбогдолтой болсныг хууль зүйн ухааны доктор М.Алтан-Очир "Хорих ял эдлүүлэх дэглэм"² бүтээлдээ дурджээ. Энэхүү заалт нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 2017 оны шинэчилсэн найруулгын 197.2-т *Хорих ангийн үйлдвэрлэлийн чиглэлийг аймаг, нийслэлийн Засаг дарга болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ* хэмээн санал гаргах субъектэд төв байгууллагын даргыг нэмж, шийдвэрлэх субъектыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болгон өөрчлөн найруулсан нь хоригдлыг хөдөлмөрөөр хангах үйлдвэрлэлийг орон нутгаас гадна хорих байгууллагын онцлогт тохируулж, хууль хэрэгжүүлэх салбарын бодлогод бүрэн нийцүүлэх эрх зүйн зохицуулалт болж өгсөн байна.

Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар улс бүр ялгаатай ханддаг байна. Жишээлбэл, ОХУ-ын эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх хуулиар (Уголовно-исполнительный кодекс) бүх хоригдол албадан хөдөлмөр хийх ёстой байдаг бол Европын орнууд, АНУ, Япон зэрэг улсуудад хоригдлын хөдөлмөр бол албадан хөдөлмөр гэсэн логигоор ханддаг байна.

Хорих ял эдлүүлэх тодорхой хугацаанд олон нийтээс зөвхөн тусгаарлах бус сэтгэл зүйн сургалт, хөтөлбөрт хамруулах, хууль тогтоомжийн болон бусад хэм хэмжээг ойлгож, сайн дураар дагаж мөрдөх, нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцоход дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах, хөгжүүлэх, хөдөлмөрлүүлэх нь улс орон болгонд ялгаатай тал байдаг ч зарим талаараа нийтлэг

зохион байгуулагдаж байна.

Жишээ нь: Америкийн Нэгдсэн Улсын Холбооны пенитенциар систем нь хамгаалалтын зэрэглэл болон аюулгүйн бага, дунд, дээд түвшинтэй байдаг. Бага болон дунд түвшинд хоригдлыг хөдөлмөрлүүлэх боломжтой гэж заасан байна.

Хоригдлуудыг хөдөлмөрлүүлэх асуудлыг дэд актуудаар зохицуулж байсан бөгөөд мэргэжил боловсролын чадвар олгох, эргээд чөлөөт нийгэмд амьдрахад туслах, тохирсон хөлс олгох, хөдөлмөр болон сургалтад сайн дураар хамруулах, хөдөлмөрийн таатай нөхцөлөөр хангагдах, хорих байгууллага үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай зөвшилцөн хамтран ажилладаг.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хувьд хоригдлуудыг нийгэмшүүлэх зорилгыг нэн тэргүүнд тавьж, хөдөлмөр эрхлэхийг үүрэг болгосон байдаг.

Оросын Холбооны Улсын хувьд эрүүгийн ялын гүйцэтгэлийн тухай хуульд зааснаар ялтан бүр хорих ял эдлүүлэх байгууллагын захиргаанаас тодорхойлсон газарт хөдөлмөрлөх үүрэгтэй. Ингэхдээ тус улсын хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид заасан ажлын цаг, дүрэм, эрүүл ахуй, аюулгүй байдал гэх мэт шаардлагад нийцсэн байх ёстой гэж заасан байна.

Япон Улсад засрал хүмүүжил олгох, нийгэмшүүлэх үндсэн хэрэгсэл нь хөдөлмөр гэж үздэг. Цалин хөлстэй ажлын байрын хувьд орлогыг үндэсний санд төвлөрүүлж, суллагдах үед нь тодорхой хувийг суутгаж олгодог байна. Хууль зүйн асуудал эрхэлсэн ямаар дамжуулж гаднын үйлдвэр эрхлэгчидтэй гэрээ байгуулан ажилладаг байна.

Бүгд Найрамдах Солонгос Улсын ял эдлүүлэх болон хоригдлын эрх зүйн байдлын тухай хуульд хөдөлмөр эрхлэлт нь тэдний эрх чөлөөт амьдралд эргэж ороход нь туслах зорилгоор ажлын дадал, мэргэжлийн ур чадвар олгох, хөдөлмөрт хандах сонирхлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна. Ингэхдээ нас, ялын хугацаа, эрүүл мэндийн байдал, ур чадвар, зан төлөв, хүсэл сонирхол, мэргэжлийн чадвар зэргийг харгалзан үздэг байна.

Дээрх улс орон бүрт тухайн улсын хөдөлмөрийн тухай болон бусад хууль, журамтай нийцүүлж, хоригдлын хувийн болон бусад олон талын онцлогийг харгалзан зохион байгуулж байгааг ажиглаж болно. Хөдөлмөрийн нийгэмшүүлэх ач холбогдол А.Г. Левицкаягийн тэмдэглэснээр хоригдлууд хөдөлмөрлөх эрхээ шууд хязгаарлуулдаг байна: нэгдүгээрт, хууль тогтоомжоор; хоёрдугаарт, хорих байгууллагын боломж бололцоогоор гэж тэмдэглэсэн байна.

Цаашилбал, хүн бүрийн сэтгэл зүйн үндсэн онцлогтой холбоотойгоор аливаа үзэгдэл, үйл ажиллагаанд хариу үйлдэл үзүүлэх, зохицох чадавх ялгаатай байдаг. Нас, хүйс, ялын хугацаа, дэглэм, эрүүл мэндээс дутахааргүй чухал энэхүү онцлогийг харгалзан хөдөлмөрт хуваарилбал ажлын бүтээмж дээшлэх, зөв зан үйл төлөвших процессыг хялбаршуулах боломжтой.

Анхаарал төвлөрөлт сул, сэтгэл хөдлөмтгий, сэтгэцийн үйл гадагш чиглэсэн хүнд сийлбэр, үйлдвэрийн тоног төхөөрөмжтэй харьцах гэх мэт тэвчээр, нарийн мэдрэмж шаардсан, байнга нэг хэвийн давтамжтай үйлдэлтэй ажил хийлгэх нь сэтгэл зүйн хувьд тогтворгүй, залхсан, бүтээмжгүй болох, хөдөлмөрөөс залхах сөрөг үр дагавар дагуулах магадлалтай. Эсрэг тохиолдолд сэтгэхүйн хурд, анхаарлын шилжилт удаан, сэтгэцийн үйл дотогш чиглэсэн хүнийг олон хүнтэй харьцсан, бие биеэсээ хамааралтай ажил хийлгэх, эсвэл нэгэн зэрэг олон үйлдэл хийхийг шаардсан ажил хийлгэх нь мөн адил үр дагавар авчрах хандлагатай.

Өнөө үед хорих байгууллагын аж ахуй, үйлдвэрлэлийн онцлог, нөхцөл байдлаас хамаараад хоригдол тус бүрийн мэргэжил, ур чадварын онцлогт тохирсон ажлыг хийлгэх боломж нь хязгаарлагдмал хэдий ч дээрх жишээтэй адил байдлаар сэтгэл зүйн онцлогийг харгалзан хөдөлмөрлүүлэх нь хорих ангийн үйлдвэрлэл, гэрээгээр ажил гүйцэтгүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээг хангаад зогсохгүй хөдөлмөр эрхэлж буй хоригдлын нийгэмшилд чухал ач холбогдолтой юм.

Үүнээс үзвэл хорих ял эдэлж буй хүмүүсийг хөдөлмөрлүүлэх үйл ажиллагаа өвөрмөц онцлогтой бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан дэглэм, зэрэглэлийн онцлог тохируулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаатай холбоотой хууль тогтоомжуудад нийцүүлэх, хүний эрхийг хангаж, албадан хөдөлмөр эрхлүүлэхгүй байх, эрүүгийн хариуцлагын зорилго болох хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд цалинтай хөдөлмөр эрхлүүлэх, тэр байтугай хоригдлын сэтгэл зүйн онцлогийг хүртэл харгалзан, зөв зохион байгуулах нарийн төвөгтэй асуудал юм.

Хөдөлмөр нь өөртөө үйлчлэх, бусдад үйлчлэх хэлбэрээр хэрэгжиж, ажил хөдөлмөр эрхлэхэд сэтгэл зүйн хувьд болон дадал зуршлын бэлтгэлийг хангах, өөрийн хүч хөдөлмөрөө үр ашигтай, зөв зохион байгуулах, ажил хэрэгч хандлагатай болж, бэлэнчлэн хялбар, хууль бус аргаар амьдрах сэтгэлгээг даван туулах төлөвшилийг хүнд бий болгодог.

Хоригдлуудаар хөдөлмөр эрхлүүлэх замаар бие хүний төлөвшил олгож байгаагийн хувьд хөдөлмөрөөр залхаах, эсвэл хөдөлмөрийг үзэн ядах үр дагавар үүсгэхгүй байхад онцгой анхаарах хэрэгтэй.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр батлагдан гарсан “хоригдлыг суллагдах үед бэлтгэх” хөтөлбөр батлагдсан байна.

Хоригдлоор ажил, хөдөлмөр эрхлүүлэхдээ зөвхөн хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагын ашиг сонирхолд нийцүүлж бус хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах нь чухал бөгөөд энэ тухай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 214 дүгээр зүйлийн : 214.1-д "Хоригдлын хөдөлмөрийг холбогдох хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журамд нийцүүлэн зохион байгуулна" гэж заасан.

Гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлсэн этгээдийн хувьд сөрөг зан үйлээ өөрчлөхөд хүчтэй нөлөөлөх хүчин зүйл бол зөв зүйл хийснийх нь төлөө тухайн хүнд ирэх урам, урамшуулал байдаг. Өөрөөр хэлбэл хөдөлмөр эрхлэлтэд нь тохирсон урамшуулал олгох асуудал юм. Хорих ангийн дэг журмыг чанд сахиж, хөдөлмөрлөх үүргээ амжилттай биелүүлсэн хоригдлыг хорих ангийн даргын шийдвэрээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай . хуулийн 223 дугаар зүйлийн 223.1.1-д түр, удаан хугацааны уулзалтын тоог 45 хоног тус бүр нэгээр нэмэгдүүлж, 223.1.2-т хуульд заасан журмын дагуу шагналын хоног олгож, 223.1.3-т хорих ангийн дотоод журмын дагуу хориглоогүй үнэ бүхий эд зүйлээр тус тус урамшуулах зохицуулалттай. Эдгээрээс хоригдлуудад хамгийн үр нөлөөтөйд тооцогддог нь шагналын хоногоор урамшуулах явдал юм. 1929 оноос эхлэн хоригдлыг ажлын хоногоор шагнаж, эдлэх ялаас нь хасч ирсэн түүхтэй

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 224 дүгээр зүйлийн 224.3-т Хоригдол энэ хуулийн 224.1-д заасан шаардлагыг хангасан, хөдөлмөрт хамрагдсан хугацаа нь ял эдэлж байгаа хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст

тухайн сард ажилласан хугацаа нь дангаар, эсхүл шилжин ирэхээс өмнө ял эдэлж байсан хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд ажилласан хугацааны нийлбэр нь 160 цагаас доошгүй тохиолдолд ажлын бүтээмж, чанарыг үндэслэн 1 сард 10 хүртэл хоногийн шагналын хоног олгохоор заажээ.

Үйлдвэрлэл болон ШШГБ-ын аж ахуйн ажлуудыг гүйцэтгэхдээ тухайн сард эрүүл мэндийн шалтгаан, сургалт, нийгэмшүүлэх ажилд хамрагдах, түр болон удаан хугацаагаар уулзах зэргээр өөр зүйлд цаг зарцуулах, зарим тохиолдолд цаг үеийн шинжтэй буюу богино хугацаанд гүйцэтгэх ажлын онцлогоос хамаарч 160 цагаас бага хугацаагаар ажиллах тохиолдол гардаг. Уг заалт нь тэдгээр хоригдлуудын хөдөлмөрийг үнэгүйдүүлэх, хөдөлмөрийн нийгэмшүүлэх үр нөлөөг бууруулах сөрөг үр дагавар учруулдаг байна.

Ажил олгогч нь ажилтанд түүний хүсэлтээр чөлөө олгох асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-д хуульчилсан. Үүнийг ажил гүйцэтгэх гэрээний үндсэн дээр хөдөлмөр эрхэлж байгаа хоригдол, хорих ангийн захиргаа хоорондын харилцаанд мөн хэрэгжүүлж, ажлын цагаас хасагдах / шалтгаан болж байгаа дээрх үндэслэлүүдийг хамааруулж, хүндэтгэн үзэх шалтгааныг ажлын цагт оруулан тооцох хууль эрх зүйн үндэслэлийг бий болгох боломжтой.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 224 дүгээр зүйлд заасны дагуу шагналын хоногоор урамшуулах асуудлыг сар бүр Арга зүйн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцдэг бөгөөд хөдөлмөр эрхэлсэн хоригдлуудад шагналын - хоногоор урамшуулахад ажилласан цагийн бүртгэл, ажлын бүтээмж, гүйцэтгэл гол үндэслэл болдог. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр” батлагдан гарсан. Хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлгийн залуучуудын хөгжил, оролцоог дэмжих хүрээнд хэрэгжүүлэх уг хөтөлбөрт хорих ялын хугацаа дуусахаас өмнө хоригдлыг нийгэмд гарахад бэлтгэх, суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, суралцах, ажил хөдөлмөр эрхлэх дадал хэвшүүлэх, гэр бүлийн харилцаа, хөдөлмөрийн харилцаанд бэлтгэх, нийгэмшүүлэхэд чиглэсэн олон талын арга хэмжээг хэрэгжүүлэх.

Мөн хөдөлмөрийн дадал олгох, мэдлэг, ур чадварыг үнэлэх, баталгаажуулах гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулах бөгөөд ингэснээр нийгмийн амьдралд дахин хөл тавьж буй залуучууд богино хугацаанд ажлын байртай болох, өрхийн орлогоо дэмжих, цаашилбал хамт олон дунд төлөвших, дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдох эрсдэлийг бууруулах ач холбогдолтой юм.

Хөтөлбөрийн хүрээнд тухайн жилд суллагдсан залуучуудын 70-аас доошгүй хувийг сургалтад хамруулж, 50-аас доошгүй хувийг ажлын байраар хангаж, дахин гэмт хэрэгт холбогдолтыг 10 аас доошгүй хувиар бууруулах зорилготой үйл ажиллагааг зохион байгуулахаар болсон байна.

2020 оны байдлаар улсын хэмжээнд нийт хорих ял эдлэгсдийн 70 орчим хувийг хөдөлмөрт хамруулж байгаагаас талаас илүү хувь нь ангийн аж ахуйн үйлчилгээнд ажилладаг. Хоригдлын хийж буй ажлыг технологийн дагуу явуулах нь тухайн ажил хөдөлмөрийн талаарх зөв мэдлэг, туршлагатай болж төлөвших, гүйцэтгэлийг бодитой үнэлэх нь түүнд тохирсон урамшуулал олгох боломжийг бүрдүүлэх юм.

Мөн хуулийн 199 дүгээр зүйлийн 199.6-д Хаалттай хорих ангид ял эдэлж

байгаа хоригдлыг зөвхөн хорих байгууллагын үйлдвэрлэлд хөдөлмөрлүүлнэ, 214 дүгээр зүйлийн 214.7-д Нээлттэй хорих ангийн хоригдлыг хүсэлтийг нь үндэслэн хаалттай хорих анги, цагдан хорих байр, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, хорих эмнэлгийн аж ахуйн үйлчилгээнд хөдөлмөрлүүлж болно гэж тус тус заажээ.

Нээлттэй дэглэмтэй хоригдол хаалттай дэглэмийн аж-ахуйн үйлчилгээнд ажиллах үндэслэл зөвхөн түүний сайн дурын үндсэн дээр, хүсэлт гаргаснаар үүснэ. Бусад тохиолдолд хаалттай хорих ангийн аж ахуйн ажлыг гүйцэтгүүлэх боломжгүй бөгөөд хуулийн 199.6-д зааснаар хаалттай дэглэмтэй хоригдлыг зөвхөн хорих байгууллагын үйлдвэрлэлд ажиллуулахаар хязгаарласан байна.

Хуулийн 214 дүгээр зүйлийн 214.3-т Хоригдлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх, байгууллагын аж ахуйн ажлаас бусад ажилд хөлс, урамшуулалгүйгээр хөдөлмөрлүүлэхийг хориглоно, 214.9-д Хуульд өөрөөр заагаагүй бол хоригдлыг төрийн нууц, цэрэг стратегийн холбогдолтой болон тусгай дэглэм бүхий онцгой объектод хөдөлмөрлүүлэхийг хориглоно, 214.5-д Хоригдлоор ажил хийлгэхдээ түүний мэргэжил, хөдөлмөрийн чадварыг харгалзах бөгөөд мэргэжлийн ажил байхгүй нь түүнийг хөдөлмөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй, 214.2-т Хорих анги хоригдлыг хөдөлмөрлөх, тодорхой чиглэлээр мэргэжил эзэмшүүлэх, дадлага олгох тэгш, нөхцөл, боломж бүрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ гэж тус тус заасан.

Хуулийн дээрх заалтуудад хоригдлыг хөдөлмөрлүүлж болохгүй ажлын байр, хөдөлмөрөөс чөлөөлөхгүй байх, хөдөлмөрлөх үүрэгтэй болох тухай, хорих анги хоригдлыг хөдөлмөрлөх боломж бүрдүүлэх арга хэмжээ авах тухай тодорхой заасны дагуу үйлдвэрлэлээс гадна өрөө байр, цэвэрлэгээ, хоол үйлдвэрлэл, түүнтэй холбоотой ажлууд, галч, номын санч, мал аж ахуй, газар тариалан, засвар үйлчилгээ зэрэг ажлуудыг хийлгэж, хөдөлмөрлөх нөхцөлөөр хангадаг. Практикт мал маллах, мах хүнс, нүүрс түлээ бэлдэх зэргээр аж ахуйн ажлыг хязгаарлан ойлгох хандлага байгаа нь хуулийн заалтыг хэрэгжүүлэгч болон хуулийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллага нэг мөр ойлгоход нэр томьёоны утгыг хуульчилж, тайлбарлаж өгөх шаардлага гарч байна.

1931 оны “Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн, ялтныг засан сайжруулах ажлын тухай хууль”-д ажлыг Засан сайжруулах газрын дотор ба гадна хэмжээнд 2 анги болгон хуваарилахын дээр тэдгээрийг аж ахуйн ба үйлдвэрийн 2 ангилдаг байжээ. Аж ахуй ажил нь Засан сайжруулах газрын өдөр тутмын аж ахуйд холбогдох зүйлүүд бөгөөд түүнд хоригдогсдоос тусгай хүмүүсээр, эсвэл ээлжээр харгалзан томилон гүйцэтгэнэ. Үйлдвэрийн ажлыг Засан сайжруулах газар аливаа урлах, дархлах газрыг байгуулан хоригдогсдоор гүйцэтгүүлэхээс гадна аливаа албаны ба ард олноор байгуулсан газруудтай хэлэлцэж ажил үйлдвэрт хэрэглүүлж болно гэж тухайн үедээ тодорхой зааж байжээ.

Дүгнэлт, санал

Хоригдлыг хөдөлмөрлүүлэх, ажлын дадлага туршлага суулгах нь манай улсын болон бусад улс орны нийгэмшүүлэх ажлын тулгуур болж байна. Хоригдлыг хөдөлмөрөөр хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх нь нэг талдаа чухал ач холбогдолтой боловч суллагдаж гарсан этгээд нь тухайн ажлын сурсан дадлаараа цаашид амьдралаа авч явж байгаа нь эргэлзээтэй. Энэ нь тухайн хорих байгууллага, газар, хэлтсийн үйлдвэрлэл, үйлчилгээтэй шууд холбоотой байна. Хөдөлмөрийн дадал олгох сургалтыг хоригдлуудын сонирхол туршлагад

тулгуурлаж тодорхой хэм хэмжээнд зохион байгуулах нь илүү ач холбогдолтой гэж үзэж байна.

Бусад байгууллагатай хамтран ажиллах уялдааг илүү ихээр нэмэгдүүлж холбох үүрэгтэйгээр ажиллах нь оновчтой гэж үзэж байна.

Цаашид хоригдлын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хөдөлмөрийн дадал зуршлыг суулгах.

Хоригдлыг хөдөлмөрөөр хангах үйлдвэрлэлийн чиглэлийг тогтооход орон нутгийн Засаг дарга санал оруулах субъектын нэг болж хуульчлагдсан нь үйлдвэрлэлийн үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг борлуулах, ашиглах, эргэлтэд оруулах зөв зохицуулалт бөгөөд хөдөлмөрийн хөлс, урамшууллын тодорхой хувийг гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг барагдуулах ихээхэн ач холбогдолтой боловч орон нутагтай хамтран ажиллах уялдаа холбоо хангалтгүй байна.

Хоригдлын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх түүнд тохирсон урамшуулал, хамгийн гол нь зөв зан үйл, дадал төлөвших процесст хоригдлын нас, хүйс, ялын хугацаа, дэглэм, эрүүл мэнд зэргээс гадна сэтгэл зүйн онцлог, үйл ажиллагаанд хариу үйлдэл үзүүлэх, зохицох чадварын ялгаатай байдлыг харгалзан хөдөлмөрт хуваарилах ажлын судалгаа шинжилгээ хийж, практикт нэвтрүүлэх.

Хорих ангидах үйлдвэрлэлийн чиглэл нь зах зээлийн шаардлагад нийцэж хувирах, өргөжих, өөрчлөгдөх.

Аж ахуйн ажлын талаарх нэр томъёоны утгыг хуульчилж, эрх зүйн зохицуулалт бий болгох зэрэг болно.

Хорих ангиудад хоригдлуудын гүйцэтгэж буй үйлдвэрлэл, ажлыг технологийн дагуу явуулж, гүйцэтгэлийг бодитой үнэлэх замаар тухайн ажил хөдөлмөрийн талаарх зөв мэдлэг, туршлагатай болж төлөвшүүлэх, хөдөлмөрийг залгах үр дагавар үүсэхээс урьдчилан сэргийлэх.

Эх сурвалжийн жагсаалт

1.Р.Оюунбадам, Н.Ганхуяг, Г.Галсанжамц. Хорих байгууллага дахь нийгмийн ажил, Уб., 2015.122

2.А.Лхагва, М.Ганхүү. Хорих ял эдлэгсдийг хүмүүжүүлэх-нийгэмшүүлэх ажлын зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтын зарчим асуудал, Уб., 2015. 13,

3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2017. 214,215,216,217,219,221,223,224

4.Б.Галбадрах. Хоригдлын эрхийн байдал, Уб., 2021.36,37,38,39

5.ШШГБ-ын 2020 оны судалгаа

6.ШШГБ-ын Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2020.,135

---o0o---